



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-
ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар
2023 оны 1-р сар

1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшнийг сайжруулахад оршино.

1.2. "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.

1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилдтооцно.

1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.

1.5. Хөрөнгийн биржийн зүгээс "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

2. “ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, ДҮН

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11		
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7		
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		
5	Эрсдэлийн удирдлага	8	5		
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		
8	Компанийн соёл	6	6		
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9		
	Нэгдсэн дүн	72	64		

Энэхүү хүснэгтэд заасан нэгдсэн дүнгээс харахад “Жуулчин Дюти Фрий ХК нь “Компанийн засаглалын кодекс” хэрэгжүүлэлтийн үнэлгээ 88,8%-тай гарсан байна.

3. “ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ: Үүнд:

3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсэж болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;

3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;

3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

4. “ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	“Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн ТУЗ2020-03/09 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгаж заасан байдаг. КЗК-ийн дагуу 2023 оны 1-р улиралд багтаан тус журмынхаа агуулгыг илүү сайжруулан батлахаар төлөвлөж байна.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	“Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн ТУЗ 03/03 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан “Нэр дэвшүүлэх хорооны дүрэм”-д ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан. Энэхүү журмыг 2023 оны 1-р улиралд багтаан шинэчлэн батлахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн Залгамж халааны бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн гишүүдийн анх нэр дэвшүүлэхэд ХЭХ-д кандидатуудын боловсрол, ажлын туршлага, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь зэргийг танилцуулдаг. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан	1	50%

	ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.		хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд товч тусгадаг. КЗК-д заасны дагуу тайлагнаж, цахим хуудсандаа байршуулан ажиллана.		
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	"Жуулчин Дюти Фрий" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн ТУЗ2020-03/09 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д дэргэдэх хороодын чиг үүрэг бүтэц бүрэлдэхүүн мэргэжил ур чадварыг заасан байдаг. ТУЗ болон түүний дэргэдэх хороод нь журамд заасан шаардлагыг дагуу үйл ажиллагаа явуулж байна.	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүдийг компанийн үйл ажиллагаатай танилцуулах сургалтыг 2020 онд зохион байгуулсан. ТУЗ нь 4 жилийн хугацаатай томилогддог. Мөн ТУЗ-ийн гишүүдийн тухай бүр шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллаж байна.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн НБД-ыг ТУЗ-ийн дарга санал болгож ТУЗ-ын хурлаас томилдог. ТУЗ-ийн НБД нь хурал болон дэргэдэх хороодын хурлын төлөвлөгөөг гаргаж, цаг тухайд нь хурал зохион байгуулах, тайлан мэдээг илгээх, бичиг хэрэг хөтлөлт, ХЭ-ийг мэдээ мэдээллээр хангах зэрэг ажлыг хариуцан ажиллаж байна.	2	100%
ДҮН				11	
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь		ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу 9 гишээс хараат бус 3 гишүүнтэй ажилладаг. ТУЗ-ийн	2	100%

	хараат бус гишүүн байхыг зорино.		хараат бус гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх хороодод 3/1 нь ажиллаж байна. Хараат бус гишүүд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ажиллаж байна. Компани нь Хараат бус гишүүдийг тоог нэмэгдүүлэхийг зорин ажиллана.		
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүрмийг ТУЗ-ийн 2017 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ 03/01 дугаартай тогтоолоор баталсан. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, ердийн гишүүн ажиллаж байна. 2023 оны 1-р улиралд багтаан КЗК-ийн дагуу хараат бус гишүүн томилон ажиллуулахаар төлөвлөж байна.	1	50%
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны дүрмийг ТУЗ-ийн 2017 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ 03/02 дугаартай тогтоолоор баталсан. ТУЗ-ийн даргаар ТУЗ-ийн дарга бус, ердийн гишүүн байна. 2023 оны 1-р улиралд багтаан хараат бус гишүүн томилон ажиллуулахаар төлөвлөж байна.	1	50%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны дүрмийг ТУЗ-ийн 2017 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ 03/03 дугаартай тогтоолоор баталсан. ТУЗ-ийн даргаар ТУЗ-ийн дарга бус, ердийн гишүүн байна. 2023 оны 1-р улиралд багтаан хараат бус гишүүн томилон ажиллуулахаар төлөвлөж байна.	1	50%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж	Бүрэн хэрэгжүүлсэн.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ нь дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог	2	100%

	болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.		байгуулж болохоор журамд заасан. Энэхүү журамд заасны дагуу шаардлагатай тохиолдолд чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулахад энэхүү зохицуулалтыг дагаж ажиллана.		
ДҮН				7	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ нь мэдээллийн ил тод байдал, тайлагналын журамтай бөгөөд СЗХ-ны үнэт цаасны бүртгэлийн журам шинээр гарсантай холбоотой журмаа шинэчлэн батлахаар ажиллаж байна. Мөн Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээллээ хүргүүлж байна.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ нь баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байна.	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Санхүүгийн тайлан болон санхүүгийн бус тайлан мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол холбогдох байгууллагуудад хүргүүлэн Хөрөнгийн биржийн сайтад мэдээлдэг. Томоохон төсөл хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэрийн ТУЗ-д танилцуулан хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байна. Цаашид тайлагналын агуулгаа тасралтгүй сайжруулан ажиллана.	2	100%
ДҮН				6	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журамд тодорхой тусгасан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна	2	100%

	чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.				
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жил бүр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр хөндлөнгийн аудитын байгууллагаас төлөөллийг биечлэн оролцуулж, хувьцаа эзэмшигч нарыг хөндлөнгийн аудитораас асуулт асууж, мэдээлэл авах боломжоор ханган ажилладаг.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жилийн үйл ажиллагааны тайланд дотоод аудитын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг мэдээллийг тусгадаг. Цаашид компанийн зүгээс дотоод хяналтын тогтолцоог тасралтгүй сайжруулах тал дээр анхааран ажиллана.	2	100%
ДҮН				6	
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Гүйцэтгэх удирдлагын тайлан болон санхүүгийн мэдээлэлд үндэслэн ТУЗ хяналт тавьж байна. Эрсдэлийн удирдлагын бүтэц одоогоор байхгүй байна. Эрсдэлийн удирдлагын бүтцийг 2023 оны 1-р улиралд багтаан батлахаар ажиллаж байна.	1	50%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Компанид одоогоор эрсдэлийн удирдлагын хороо байхгүй байгаа боловч шийдвэр гаргалтын эрсдэлийн асуудлыг ТУЗ-ийн хурлаар тухай бүр хэлэлцдэг. Цаашид эрсдэлийн удирдлагын хороотой болохоор төлөвлөн. Хорооны дүрмийг боловсруулах шатанд ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2023	1	50%

	<i>болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>		оны 1-р улиралд багтаан батлахаар ажиллаж байна.		
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	Жилийн үйл ажиллагааны тайлангийн Тогтвортой хөгжлийн тайлан хэсэгт тайлагнадаг.	2	100%
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Комплайнсын хяналтын заавар болон бүтцийг ТУЗ-өөр батлуулахаар төслийг боловсруулаад байгаа бөгөөд тэдгээрийг 2023 оны 2-р улиралд багтаан батална.	1	50%
ДҮН				5	
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн Дүрмийн дагуу ТУЗ нь ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээг тогтоодог бөгөөд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын мэдээллийг Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнаж ажилладаг.	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг Цалин, хөлс олговор, хангамжийн журмын дагуу зохицуулан ажиллаж байна.	2	100%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлангаас эхлэн гүйцэтгэлийн шалгуурыг тусган ажиллана.	2	100%

	гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.				
ДҮН				6	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Компанийн дүрэмж, журамд бусад оролцогч талуудтай харил-цахад баримтлах зарчмууд тусгагдсан бөгөөд мөрдөж ажилладаг. Ажилтан, харилцагч, нийлүүлэгч, зээлдүүлэгч нартай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаж тогтсон	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Тайланд энэ тухай тусгадаг. Ихэвчлэн зорилт үр дүнгээ дэлгэрэнгүй тусгаж оруулдаг. Энэ асуудлыг хоёр талын гэрээгээр зохицуулж ирсэн.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Үйл ажиллагааны онцлогоос хамаарах цахим хуудсыг төдийлөн ашигладаггүй.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Ажилтнуудын санал хүсэлтийг дотоод teams.mn системээр дамжуулан авч эхэлсэн. Өмнө нь өргөдөл хэлбэрээр авдаг байсан. Ажилтнуудыг чадавхжуулахад чиглэсэн сургалтуудыг гадны байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлдэг. Ажлын төлөвлөгөөг Хөдөлмөрийн дотоод журам-аар зохицуулан жил, улирал, сараас төлөвлөгөө гарган ажилладаг.	2	100%
ДҮН				8	
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					

ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Ёс зүйн дүрэм байхгүй боловч Компанийн үнэт зүйлсэд тусгасны дагуу ёс зүйтэй, хариуцлагатай, шударга байхад чиглэн ажилладаг. 2023 оны ТУЗ-ийн ээлжит хуралд Ёс зүйн хороог байгуулах, холбогдох баримт бичиг, дүрэм журмыг батлуулан ажиллана.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Толгой компани болон Таван Богд Трейд ХХК-ийн Ёс зүйн дүрмийн дагуу шүгэл үлээх тогтолцог дагаж мөрдөн ажиллаж байна. Бие даасан тогтолцоог хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.	2	10%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Ёс зүйн дүрэм байхгүй боловч Компанийн үнэт зүйлсэд тусгасны дагуу ёс зүйтэй, хариуцлагатай, шударга байхад чиглэн ажилладаг. 2023 оны ТУЗ-ийн ээлжит хуралд Ёс зүйн хороог байгуулах, холбогдох баримт бичиг, дүрэм журмыг батлуулан ажиллана.	2	100%
ДҮН				6	
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	"Жуулчин Дюти Фрий ХК" нь оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг МХБ-ийн цахим сайтаар тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажилладаг.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Хөрөнгө оруулагч нарт мэдээлэл хүргүүлэх зорилгоор холбогдох утас, цахим хаягийн дагуу мэдээллийн сувгийг ашиглаж байна.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах,	Бүрэн хэрэгжүүлсэн.	Хөрөнгө оруулагч нарт мэдээллийг холбогдох утас, цахим мэйл ашиглан хүргүүлж байна. ХЭ-ийг	2	100%

	санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.		хуралд оролцох, саналаа өгөх боломжийг биеэр болон онлайнаар, зайнаас оролцох системийн тусламжтайгаар бүрэн хангадаг. Энэ асуудлыг холбогдох журмын дагуу мөрдөж ажилладаг		
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн.	Өнөөдрийн байдлаар ийм асуудал үүсээгүй байна. Шаардлага гарвал журмын дагуу ажиллана.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	Одоогоор ийм журам байхгүй байна. Сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх журмыг 2023 оны 1-р улиралд багтаан батлан мөрдөн ажиллана.	1	50%
ДҮН				9	
НЭГДСЭН ДҮН				64	88,8%

ДҮГНЭЛТ

“Жуулчин Дюти Фрий” ХК нь олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.

2022 онд шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг эхний удаа үнэлж үзэхэд 88.8% буюу дунд засаглалтай гэсэн үр дүнтэй гарлаа. Энэ нь бидэнд анхаарч сайжруулах зүйлсээ олж харах боломжийг олгож байгаа бөгөөд бид энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Үнэлгээ хийсэн:

ТУЗ-ийн Хараат бус гишүүн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:



В.Хүрэлхад

Б.Бат-Эрдэнэ